

ЖИЛИЙН ТАЙЛАН  
ANNUAL REPORT

2002


Загвар  
Формат: А4  
Хавтас: 200гр арт, матт бүрэлт  
Дотор: 157гр арт  
Өнгө: 4+4



Улаанбаатар хотын банк  
Ulaanbaatar City Bank



Улаанбаатар хотын банк  
Ulaanbaatar City Bank



ЖИЛИЙН ТАЙЛАН  
МОНГОЛ MONGOLIA  
ANNUAL REPORT

**2002**

# Улаанбаатар хотын банк

## Ulaanbaatar City Bank

### Агуулга Contents

1. Монгол улсын нийгэм, эдийн засгийн тойм Brief review of the Mongolian economy	4
2. Улаанбаатар хотын банкны үүсэл, хөгжил Brief history of Ulaanbaatar City Bank	8
3. Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд Financial highlights	9
4. Гүйцэтгэх захирлын мэндчилгээ President and CEO's address	10
5. Банк, санхүүгийн систем Banking and financial sector	12
6. Улаанбаатар хотын банкны эрхэм зорилго, стратеги Genuine goal and strategy of Ulaanbaatar City Bank	15
7. Зохион байгуулалтын бүтэц Organizational chart	16
8. Санхүүгийн тайлан Financial report	19
9. Банкны шалгуур үзүүлэлтүүд Performance ratio	25
10. Хөндлөнгийн хяналтын тайлан Auditor's report	28
11. Банкны хаяг, байршил Branches	36



1. Нутаг дэвсгэр Area	1,56 сая км кв. 1,56 mln. sq.km.
2. Хүн ам Population	2,5 сая 2,5 mln.
3. Нийслэл Capital	Улаанбаатар Ulaanbaatar
4. Хүн амын жилийн дундаж өсөлт Annual Growth in Population	1,4 %
5. 1 кв. км талбайд ногдох хүний тоо Population per sq. km.	1,5
6. Мөнгөний нэгж Currency	төгрөг tugrog

## Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

### Main Economic Indicators

	( % )	
	2002	2001
1. ДНБ-ийн жилийн өсөлт Average annual growth in GDP	3,7	1,1
2. Инфляци, жилийн эцсээр /1995=100/ Inflation (1995=100)	1,6	8,0
3. АҮБ-ийн үйлдвэрлэлийн өсөлт /1995 оны зэрэгцүүлэх үнээр/ Annual growth in Industrial output /At 1995 prices/	3,8	7,4
4. Ажилгүйдлийн түвшин Unemployment rate	3,6	4,6
5. Экспортын өөрчлөлт Changes in Export	-4,3	-2,4
6. Импорттын өөрчлөлт Changes in Import	8,6	2,5
7. Төсвийн нийт алдагдал /ДНБ-д эзлэх хувиар/ Budget deficit /Percentage of GDP/	5,7	4,1
8. Мөнгө /M1/ Money /M1/	20,2	19,4
9. Мөнгө /M2/ Money /M2/	42,0	27,9
10. Валютын зах зээлийн ханш /төгрөг/ам. доллар, өөрчлөлт/ Exchange rate /MNT per USD, changes/	2,1	0,5

Жилийн  
Тайлан



**ДНБ-ийн жилийн өсөлт /%/  
Average annual growth in GDP /%/**




**Инфляци /Жилийн өөрчлөлт, %/  
Inflation /Yearly changes %/**



**Ажилгүйдлийн түвшин /%/  
Unemployment rate /%/**









## Улаанбаатар хотын банкны үүсэл, хөгжил

Улаанбаатар хотын банк нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн мөрийн хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр Улаанбаатар Сан /ҮҮГ/ – гийн хөрөнгө оруулалттайгаар байгуулагдаж 1998 оны 7 дугаар сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд 2002 оны эцсийн байдлаар тус банкны дүрмийн сангийн 51 хувийг Улаанбаатар Сан /ҮҮГ/, 49 хувийг хувь хүмүүс эзэмшиж байна.

Тус банк байгуулагдсан 1998 оноос 2002 оны эцэс хүртэл 5 жилийн хугацаанд тус банкны тэнцлийн нийт хэмжээ 9.3 дахин нэмэгдэж 12,376,9 сая төгрөгт, харилцагчдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 11.5 дахин өсч 9,024.9 сая төгрөгт тус тус хүрсэн.

Улаанбаатар хотын банк нь нийслэл Улаанбаатар хотын нийгэм, эдийн засгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулж байгаагийн зэрэгцээ Улаанбаатар хот, түүний бүх дүүргүүд болон хөдөө орон нутгийн зарим хэсэгт банкны бүхий л төрлийн үйл ажиллагааг явуулж байна.

Улаанбаатар хотын банк 2002 оны эцсийн байдлаар Улаанбаатар хот, хөдөө, орон нутгуудад 8 тооцооны төв, 7 орлогын касстайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд эдгээрт нийт 130 орчим ажиллагсад ажиллаж байна.

Тус банк 2002 оны эцсийн байдлаар Нью Иорк, Франкфурт, Цюрих, Токио – дөөрийн гадаад харилцах дансуудаа нээсэн ба бусад орнуудын ижил төстэй үйл ажиллагаа бүхий банкуудтай ажил хэргийн харилцаатай ажиллаж байна.

Улаанбаатар хотын банк нь 2000 онд "Хэрэглэгчийг хаанд өргөмжилсэн хамт олон" – оор шалгарч байв.

## Brief history of Ulaanbaatar City Bank

Ulaanbaatar City Bank was founded in July 1998 on the initiative of Ulaanbaatar City Mayor and with active support of the City's Civic Representative Khural and City Council as the first municipal bank of Mongolia. The major share of capital (51 percent) being always in the hands of Ulaanbaatar City Government represented by Ulaanbaatar Foundation, while the remaining part is held by individuals.

The primary specialization of the Bank at the beginning was to optimize centralized funds flow and to channel global investments into Ulaanbaatar City's development projects and its infrastructure. Achieving this goal, the bank became the major financial center for Ulaanbaatar City and its associated structures. The Bank performs all banking activities of a commercial bank. Presently the Bank opened 15 branches and settlement centers in Mongolia.

Since 1998 to the end of 2002, total balance of the bank grew to 12,376,9 million MNT (an increase by 9,3 times) and total deposit grew to 9,024.9 million MNT (an increase by 11,5 times).

At the end of 2002 about 130 employees were working in the head office and fifteen branches, settlement centers.

We have correspondent accounts in main financial centers of the world, such as New York, Zurich, Frankfurt am Main and Tokyo, to provide our customers with immediate transaction and other banking services.



In 2000 the bank was awarded "Customer's satisfaction" award by Mongolian Association of Protection for Customers Rights.



## Санхүүгийн үндсэн үзүүлэлтүүд Financial highlights

/сая төгрөгөөр/ /in millions of MNT/

	2002	2001
Нийт актив Total Assets	12 376,9	9 848,8
Зээл /цэвэр/ Loan, net	6 299,8	5 237,1
Татан төвлөрүүлсэн хөрөнгө Deposits	9 024,9	7 465,5
	2002	2001
Нийт орлого Total Revenues	1 782,5	1 288,4
Нийт зардал Total Expenses	945,2	1 079,1
Татварын өмнөх ашиг Profit Before Taxation	837,3	209,4
Татвар Taxation	333,3	-
Цэвэр ашиг Net Profit	504,0	209,4

**Нийт актив**  
**Total assets****Татан төвлөрүүлсэн хөрөнгө**  
**Deposits****Цэвэр зээл**  
**Loans, net****Цэвэр ашиг**  
**Net profit**



**Улаанбаатар хотын банкны Гүйцэтгэх захирлын мэндчилгээ  
President and CEO's address**



Гүйцэтгэх захирал  
Г.Буянбат

President and CEO  
G.Buyanbat

Эрхэмсэг ноёд, хатагтай нар аа,

Та бүхэнд Улаанбаатар хотын банкны 2002 оны үйл ажиллагааны тайланг танилцуулахын ялдамд банкны Захирлын зөвлөлийн гишүүдийн нэрийн өмнөөс болон хувиасаа тус банкны хувь нийлүүлэгчид, харилцагч, хадгаламж эзэмшигчид, хамтран ажилладаг байгууллага, иргэд ТА бүхэнд чин сэтгэлийн мэндчилгээ дэвшүүлье.

Өнгөрч буй 2002 онд манай банк өөрийн үйл ажиллагаагаа зах зээлийн өрсөлдөөнт байдалд зохицуулан төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдтэй нягт уялдуулан, банкны бүх төрлийн эрсдэлийн удирдлагыг оновчтой зохион байгуулж, төлбөрийн чадвараа бэхжүүлэх, харилцагчдын өсөн нэмэгдэж байгаа эрэлт, хэрэгцээнд нийцсэн чанартай, шуурхай үйлчилгээ үзүүлж, санхүүгийн зах зээлд эзлэх байр сууриа хадгалахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллаж ирлээ.

Банкны салбарт хийгдэж буй бүтцийн өөрчлөлт эрчимжиж, иргэдийн банкинд итгэх итгэл нэмэгдэж ирсний дээр тус банкнаас хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн харилцагчдад үйлчилгээгээ улам ойртуулах, төлбөр тооцоог цаг тухайд нь шуурхай гүйцэтгэхэд анхаарлаа хандуулан ажилласны дунд

Ladies and Gentlemen,

Taking an opportunity to present the year 2002 Annual Report of Ulaanbaatar City Bank I would like to express our sincere gratitude to all shareholders, customers, organizations and individuals who have been working hand in hand with us on behalf of the Director's Board and myself.

During the year 2002, we have been operational in accordance with the market competitions and activities aimed to implement monetary policy of the Government. As well as, we have paid much attention on effectively organizing all kinds of bank risk management, reinforcing its financial capabilities, providing customers with qualified services meeting with their latest demands and needs those are continuously increasing day by day and preserving the current position at the market.

As a result of intensification of structural changes to banking sector and resident's increasing reliance to the banking services along with our efforts to bring our services closer to the customers by improving our resources and to perform any payments within a short term, we could have increased the number of our customers and



харилцагчдын тоо өсөж, тус банкаар хийгдэж буй гүйлгээ улам бүр нэмэгдэж байна. Тайлант онд банкны нийт активын хэмжээ 25,7 хувиар, бусдаас татаан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 8,7 хувиар, харилцагчдын тоо 1,6 дахин, зээлийн үлдэгдлийн хэмжээ 20,3 хувиар, ашигт ажиллагаа 2,4 дахин тус тус өссөн тоо баримт нь манай банкны ажлын ололт, амжилтыг илтгэж байна.

Банк нь гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаагаа эрчимжүүлж дэлхийн томоохон банкуудтай корреспондент харилцаа тогтоон ажиллаж байна.

Тайлант онд тус банкны олсон ололт амжилтыг тэмдэглэн, банкны удирдлага, нийт ажилтнуудад итгэл найдвар хүлээлгэж, хамтран ажиллаж байгаа манай харилцагч Та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж, цаашид харилцан ашигтай хамтран ажиллахын ерөөлийг дэвшүүлье.

Та бүхнийг гүнээ хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал  
Г.Буянбат

circulation carried out by us. We are proud to announce the statistics demonstrating our successes throughout the last year such as 25,7 percent increase in total assets, 8,7 percent increase in deposits and 20,3 percent increase in loan outstanding and 2,4 times more profits and 1,6 times more customers' number.

We also intensifying our foreign relations and establishing correspondent relation with world's well-known banks.

Finally, I would like to thank you, dear valued customers who have been supporting us through all the way celebrating our successes and relying on our employees and administration from the bottom of my heart.

Very best regards and best wishes!

Sincerely yours,

President and CEO  
G.Buyanbat





## Банк, санхүүгийн систем

Монгол улсад 1991 оноос Төв банк /Монголбанк/ болон арилжааны банкуудаас бүрдсэн банкны 2 шатлалт шинэ тогтолцоо бий болсон. 2002 оны эцсийн байдлаар Монгол улсад арилжааны 16 банк үйл ажиллагаа явуулж байна.

2002 онд Монгол орны нийгэм эдийн засгийн хөгжил харьцангуй тогтвортгожиж иргэдийн банкинд итгэх итгэл нэмэгдсэн нь банкны салбарт үүссэн хямралыг даван туулахад зэрэгзээр нөлөөлсөн.

Тайлант онд Монгол улсын Их хурлаар батлуулсан Банкны хувьчалалын талаар төрөөс баримталх үндсэн чиглэлийн дагуу Монгол улсын хамгийн том арилжааны банк болох Худалдаа, хөгжлийн банкыг хувьчиллаа.

Монголбанкаас санхүүгийн секторыг хөгжүүлэх зорилгоор банк бус санхүүгийн байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх бодлого баримталж, энэ чиглэлийн үйл ажиллагааг явуулах хууль эрх зүйн орчинг бүрдүүлснээр банк бус санхүүгийн Байгууллага, хадгаламж, зээлийн хоршоод мэдэгдэхүйц нэмэгдлээ. 2002 оны эцсийн байдлаар 64 банк бус санхүүгийн байгуулага үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд арилжааны банкуудын нийт актив 448,4 тэрбум төгрөг болж өмнөх оноос 47,3 хувиар буюу 144,0 тэрбум төгрөгөөр, нийт пассив 387,1 тэрбум төгрөг болж 50,5 хувиар буюу 129,9 тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.

## Актив

Арилжааны банкуудын нийт активын 12,2 хувийг банкны нөөц, 13,6 хувийг Төв банкны үнэт цаас, 15,8 хувийг гадаад актив, 6,9 хувийг Засгийн газраас авах авлага, 51,5 хувийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээл тус тус эзэлж байна. Тайлант онд банкуудын эзэмшиж буй Төв банкны үнэт цаас 22,2 хувиар, гадаад актив 35,1 хувиар, банкны нөөц 57,5 хувиар, зээлийн өрийн үлдэгдэл 71,4 хувиар тус тус өсөж, Засгийн газраас авах авлага 5,3 хувиар буурсан байна.

## Banking and financial sector

In 1991 Mongolia introduced a two-tier banking system, with a Central Bank (Mongolbank) and commercial banks. As of the end of 2002, 16 commercial banks are operating in banking sector of Mongolia.

In 2002 Mongolia's economic development has been stabilized and customers trust in banking system increased. That had a positive impact on efforts to overcome difficulties in financial sector.

In the reporting year, one of Mongolia's biggest commercial banks, Trade and Development Bank has been privatized in accordance with the Government privatization guidelines on banking sector that were approved by State Great Khural of Mongolia.

The Bank of Mongolia has conducted a policy aimed at increasing a role of non-bank financial organizations and build strong legal framework in financial sector to ensure its stable growth. As a result, number of non-bank financial institutions were noticeably increased. As of the end of 2002, 64 non-bank financial institutions are operating in financial market of Mongolia.

In the reporting year, total assets of commercial banks amounted to MNT 448,4 billion and increased by 47,3 percent or by MNT 144,0 billion against the same period of the previous year, and liabilities 387,1 billion and increased by 50,5 percent or by MNT 129,9 billion respectively.

## Assets

Total assets were composed of the following items: 12,2 percent bank reserves, 13,6 percent BOM bills, 15,8 percent foreign assets, 6,9 percent claims on the Government, 51,5 percent loans. In the reporting years, BOM bills were increased by 22,2 percent, foreign assets were increased by 35,1 percent, bank reserves were increased by 57,5 percent, loans were increased by 71,4 percent and claims on the Government were decreased by 5,3 percent.




Банкны системийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувийн жин өмнөх оноос 1,0 пунктээр буурч 7,1 хувийг эзэлж байна.

In 2002, the ratio of non-performing loans to total loans was 7.1 percent.

### Арилжааны банкуудын нийт актив Bank's Assets

/сая төгрөгөөр/ /in millions of MNT/

	2002	2001	Өөрчлөлт, % Changes, %
Банкны нөөц Bank reserves	54 500,5	34 606,2	+ 57,5
Төв банкны үнэт цаас BOM bills	60 995,0	49 904,7	+ 22,2
Гадаад актив Foreign assets	70 715,8	52 338,6	+ 35,1
Засгийн газраас авах авлага Claims on the Government	30 742,6	32 457,8	- 5,3
АА-н нэгжүүдээс авах авлага Loans	231 449,8	135 070,6	+ 71,4
Нийт актив Total assets	448 403,7	304 377,9	+ 47,3





## Пассив ба өөрийн хөрөнгө

Арилжааны банкуудын нийт пассивын 14,9 хувийг харилцах, 63,0 хувийг хадгаламж, гадаад валютын депозит, 3,7 хувийг гадаад пассив, 6,6 хувийг Засгийн газрын хадгаламж, 1,0 хувийг бусад пассив эзэлж байна. Тайлант онд харилцах, хадгаламжийн дансны улдэгдэл системийн хэмжээнд өссөн нь иргэдийн банкинд итгэх итгэл сайжирсныг илтгэж байна.

## Liabilities

During the last year, total liabilities of the banking sector increased by 50,5 percent. Contributions to this growth came from current accounts (+19,9 billion), time savings and foreign currency deposits (+107,5 billion) and foreign liabilities (+7,7 billion). The growth in demand and time deposits is indicating a restoration of public confidence in the banking sector and improvements in solvency and liquidity positions of potential borrowers.

### Арилжааны банкуудын нийт пассив ба өөрийн хөрөнгө Bank's liabilities

	/сая төгрөгөөр/ /in millions of MNT/	
	2002	2001
Харилцах Current accounts	66 944,1	46 994,6
Хадгаламж, гадаад валютын депозит Time savings and foreign currency deposits	282 397,8	174 908,9
Гадаад пассив Foreign liabilities	16 474,0	8 823,9
Засгийн газрын хадгаламж Central Government deposits	29 665,3	35 926,8
Бусад пассив Other liabilities	4 326,9	4 094,5
Бусад зүйл Other items	/ 12 693,8/	/13 543,9/
Нийт пассив Total liabilities	387 114,4	257 204,8
Өөрийн хөрөнгө Capital funds	61 289,3	47 173,0
Нийт пассив ба өөрийн хөрөнгө Total liabilities and capital funds	448 403,7	304 377,8
		+ 47,3
		+ 48,9
		+ 50,5
		+ 86,7
		+ 61,5
		+ 42,5



Банкны мэдээлэл,  
холбооны технологийг  
олон улсын стандартад  
нийцүүлэн улам  
боловсронгуй болгох

Шинээр  
харилцагчид,  
хөрөнгө  
оруулагчдыг  
татах

Банкны  
бүтээгдэхүүн,  
үйлчилгээг  
харилцагчдын эрэлт  
хэрэгцээнд  
нийцүүлэн  
боловсронгуй  
болгож, шинийг  
нэвтрүүлэх

**Эрхэм зорилго**  
  
Харилцагч, хөрөнгө оруулагчдын  
санхүү, бизнесийн өсөн нэмэгдэж  
байгаа хэрэгцээг хангаж, баялаг  
авчирна.

**Genuine goal**  
  
Building its customers and investors  
wealth by responding to their  
increasingly diverse and sophisticated  
financial and business strategy needs.

Зах зээлийн  
хөгжил сайтай,  
дэд бүтэц  
хөгжсөн бус  
путагт банкны  
сүлжээг өргөтгөх

To expand bank's  
service in rural  
areas with good  
infrastructure and  
market


To develop the bank's  
information and  
communication technology  
in accordance with the  
international standards

To attract new  
customers and  
investors

To develop bank's  
products and services  
according to the  
customers' demand  
and need, introduce  
modern advanced  
technology



## Зохион байгуулалтын бүтэц Organizational chart





Төлөөлөн Удирдах  
Зөвлөлийн дарга  
**Я. Долгоржав**

Chairman of Representative  
Governing Board  
**Ya. Dolgorjav**



**Захирлын Зөвлөл**  
**Board of Directors**



**Д. Жаргалсайхан**  
Дэд Захирал  
**D. Jargalsaihan**  
Deputy Director



**Д. Эчик**  
Хэрэг Эрхлэх  
Газрын захирал  
**D. Echik**  
Director of Administration Department



**З. Шижирбаатар**  
Дотоод Хяналтын  
Хэлтсийн дарга  
**Z. Shijirbaatar**  
Director of Internal  
Auditing Division



**Б. Байгалмаа**  
Зээл Эдийн Засгийн  
Хэлтсийн захирал  
**B. Baigalmaa**  
Director of Credit &  
Economic Division



**Л. Даваажав**  
Санхүү Тайллан Бүртгэлийн  
Хэлтсийн захирал  
**L. Davaajav**  
Director Finance &  
Accounting Division



## Санхүүгийн тайлан

### A. Санхүүгийн үр дүн

Тайлант онд тус банк нийт 1 782,5 сая төгрөгийн орлого олж, 945,2 сая төгрөгийн зардал гарган, улсын төсөвт 333,3 сая төгрөгийн орлогын албан татвар төлж, 504,0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллав.

### Financial report

#### A. Financial Results

In the year 2002, Ulaanbaatar City Bank recorded total revenues of MNT 1 782,5 million, total expenses of MNT 945,2 million, paid income taxes of MNT 333,3 million to the State budget and made profit of MNT 504,0 million.

	2002	2001	/сая төгрөгөөр/ /in millions of MNT/ Өөрчлөлт Changes
Нийт орлого Total Revenues	1 782,5	1 288,4	+ 38,3 %
Нийт зардал Total Expenses	1 278,5	1 079,1	+ 18,5 %
Цэвэр ашиг Net Profit	504,0	209,3	+ 140,8 %

Өнгөрсөн онтой харьцуулахад нийт орлого 38,3 хувиар буюу 494,1 сая төгрөгөөр, нийт зардал 18,5 хувиар буюу 199,4 сая төгрөгөөр, цэвэр ашиг 140,8 хувиар буюу 294,7 сая төгрөгөөр тус тус өсжээ.

#### Хүүгийн цэвэр орлого

Тус банкны хүүгийн цэвэр орлого 1 474,6 сая төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оноос 48,2 хувиар буюу 479,7 сая төгрөгөөр өссөн байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад Монголбанкны үнэт цаасны хүүгийн орлого 3,5 дахин, зээлийн хүүгийн орлого 61,2 хувиар тус тус өссөн.

Харин хүүгийн зардал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 66,9 сая төгрөгөөр өсж 83,2 сая төгрөгт хүрсэн нь харилцагчдын тоо болон харилцах, хадгаламжийн дансны үлдэгдлийн өсөлттэй шууд холбоотой.

#### Хүүгийн бус орлого

Тайлант онд хүүгийн бус орлого өнгөрсөн

Total revenues increased by 38,3 percent or by MNT 494,1 million, total expenses were increased by 18,5 percent or by MNT 199,4 million, while the profit increased by 140,8 percent or by MNT 294,7 million compared to 2001.

#### Net Interest Income

Ulaanbaatar City Bank's net interest income reached MNT 1 474,6 million, which has increased by 48,2 percent over the previous year.

Income from interest on loans increased by 61,2 percent and income from securities increased 3,5 times more from the previous year.

However, interest expenses reached MNT 83,2 millions and increased by MNT 61,2 millions. The increase of the expenses was associated with increase of customer's number and deposits.

#### Non – interest Income


In the year 2002, non – interest income



оноос 34,1 хувиар буюу 100,0 сая төгрөгөөр буурсан. Хүүгийн бус орлогын хэмжээ буурахад гадаад валютын арилжаа, ханшийн тэгшитгэлийн орлого 131,2 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

decreased by 34,1 percent or by MNT 100,0 million. The decrease of the non-interest income was associated with the deacrease of the foreign currency transaction gains, which was decreased by MNT 131,2 million

### Орлогын бүтэц Income structure




### Үйл ажиллагааны зардал

Банкны үйл ажиллагааны зардал онгөрсөн оноос 60,9 хувиар буюу 415,7 сая төгрөгөөр буурсан.

### Operating Expenses

Operating expenses of the bank decreased by 60,9 percent or by MNT 415,7 million compared to 2001.

### Зардлын бүтэц Expense structure





## Б. Тайлан тэнцэл

## B. Balance Sheet

/Сая төгрөгөөр/ /In millions of MNT/

	2002	2001	Өөрчлөлт Changes
Нийт актив Total Assets	12 376,9	9 848,8	+2 528,1
Үнэт цаас Securities	2 200,0	1 198,1	+1 001,9
Зээл/цэвэр/ Loans, net	6 299,8	5 237,1	+1 062,7
Татан төвлөрүүлсэн хөрөнгө Deposits	9 024,9	7 465,5	+1 559,4
Өөрийн хөрөнгө Capital Funds	2 611,6	2 244,9	+366,7

## Актив хөрөнгийн удирдлага

Тус банкны төв болон салбарууд 2002 онд нийт 93 776,8 сая төгрөгийн гүйлгээ хийж, банкны тэнцлийн нийт хэмжээ 12 376,9 сая төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 25,7 хувиар буюу 2 528,1 сая төгрөгөөр нэмэгдсэн.

2002 онд банк нь зээлийн болон хүүгийн эрсдлийг бууруулах зорилгоор хөрөнгийн эх үүсвэрийт эрсдэлгүй активт байршуулах замаар активын чанарыг сайжруулж, төлбөрийн чадварыг дээшлүүлэх бодлого баримтлан ажилласан ба Монголбанкны үнэт цаасны үлдэгдэл 82,7 хувиар өссөн.

Энэ хугацаанд банк нийт 53 удаагийн арилжаагаар 52,4 тэрбум төгрөгийн Монголбанкны үнэт цаас худалдан авч, оны эцэст 2 200,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан.

## Зээлийн багц

Тайлант онд харилцагч байгууллага, иргэдэд 11 881,5 сая төгрөгийн зээл олгож, 10 628,1 сая төгрөгийн зээл төлүүлсэн бөгөөд оны эцсийн байдлаар зээлийн өрийн үлдэгдэл 6 299,8 сая төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны эцэстэй харьцуулахад 1 062,7 сая төгрөгөөр өсжээ.

## Asset Management

In the reporting year, the bank made transactions of MNT 93 776,8 million and total assets of the bank reached MNT 12 376,9 which has increased by 25,7 percent or by MNT 2 528,1 million over the previous year.

As a result of the bank's asset quality and liquidity improvement policy which was to place a financial resources on non-risky assets in order to decrease credit and interest rate risks, balance of securities with BOM bonds increased by 82,7 percent from the previous year.

In the year of 2002, the bank purchased BOM bonds of MNT 52,4 billion and balance of securities with BOM bonds amounted to MNT 2 200,0 million.


## Loan Portfolio

In the reporting year, the bank has disbursed loans equaling MNT 11 881,5 million and amount of MNT 10 628,1 million was repaid. Outstanding loans increased by MNT 1 062,7 million, reaching MNT 6 299,8 million.



Тус банк 2002 онд зээлийн эргэн төлөлтөд түлхүү анхаарч ажиллан Зээлийн өр барагдуулах албыг байгуулан ажилласны үр дүнд нийт 10 628,1 сая төгрөгийн зээлийг төлүүлсэн буюу зээлийн эргэн төлөлтийн өсөлтийг олгосон зээлийн өсөлттэй харьцуулахад 44,4 хувиар илүү байна.

### Зээлийн бүтэц Loan structure



Зээлийн багцын чанарыг дээшлүүлэх зорилгоор зээлийн эрсдэлийн удирдлага, урьдчилсан ба дараалсан хяналтыг сайжруулах, зээлийг хугацаанд нь төлүүлэх, хугацаа хэтрэлтээс урьдчилан сэргийлэх, чанаргүй зээлийг төлүүлэхэд ихээхэн анхаарч зохих арга хэмжээг авч ажилласны үр дүнд нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь 5,4 пунктээр буурч 9,5 хувь болжээ.

In the year of 2002, the Bank has paid extensive attention to repayment of loans. As a result, amount of MNT 10 628,1 million debt repaid and the increase of debt repayment was 44,4 percent more than the increase of credit issuance.

- Хугацаат  
Standard loan
- Хугацаа хэтэрсэн  
Past-due loan
- Хэвийн бүс  
Substandard loan
- Эргэлзээтий  
Doubtful loan
- Найдвартгий  
Loss loan

In 2002, the ratio of non – performing loans to total loans was 9,5 percent, decreasing by 5,4 basic point from the previous year. This is an indication of improvements in loan recovery and expansion of lending activities.

	/сая төгрөгөөр/ /In millions of MNT/		
	2002	2001	Өөрчлөлт Changes
Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл Non-performing loans	598,7	777,8	- 179,1
Зээлийн болзошгүй алдагдлын сан Provision for loan losses	480,1	287,9	+ 192,2
Чанаргүй зээл, зээлийн алдагдлаас хамгаалах сангийн харьцаа As a percentage of non-performing loans	80,2 %	37,0 %	+ 43,2

2002 оны эцэст тус банкны чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 598,7 сая төгрөг, зээлийн болзошгүй алдагдлаас хамгаалах сан 480,1 сая төгрөг болсон ба чанаргүй зээл болон түүний алдагдлаас хамгаалах сангийн харьцаа 80,2 хувь байна.

At the end of 2002, non – performing loans were MNT 598,7 million and provision for loan loss, which represents a coverage ratio of 80,2 percent of the total non – performing loans were MNT 480,1 million.



### Татан төвлөрүүлсэн хөрөнгө

Банкны татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ өнгөрсөн оноос 20,9 хувиар буюу 1 559,4 сая төгрөгөөр өсөж 9 024,9 сая төгрөгт хурсэн.


2002 онд инфляци буурсантай холбогдуулан хадгаламжийн дансны үлдэгдэл төлөх хүүгийн хэмжээг бууруулсан хэдий ч уг дансны үлдэгдэл тогтвортой өсөж, 2001 оны эцсээс 13,2 дахин өссөнөөс дүгнэхэд иргэдээс тус банкинд итгэх итгэл улам бэхжиж байгаагийн нэг тод илрэл юм.

### Deposit Liabilities

At the end of 2002, bank's liabilities increased by 20,9 percent or by MNT 1 559,4 million. The increase of liabilities was associated with the increase of the savings, which was increased 13,2 times or by MNT 1 587,0 million.

In conclusion, the sharp growth in time deposits is indicating a restoration of public confidence in the bank.

### Харилцахын бүтэц Deposits





### Өөрийн хөрөнгө, өөрийн хөрөнгийн өгөөж

Тайлант онд тус банкны өөрийн хөрөнгө өнгөрсөн оноос 16,3 хувиар буюу 366.7 сая төгрөгөөр нэмэгдсэн. Өөрийн хөрөнгө нэмэглдэхэд дараахь хүчин зүйл нөлөөлсөн байна. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийгдэж, үнэлгээний зөрүү 61,6 сая төгрөгөөр дахин үнэлгээний сан нэмэгдсэн.
2. Хуримтлагдсан ашиг өнгөрсөн оноос 2.4 дахин буюу 294.6 сая төгрөгөөр өссөн.


### Return on equity and return on assets

In the reporting year, the Bank's capital funds have increased by 16,3 percent or by MNT 366,7 million from the previous year. The increase in capital funds was mostly due to the MNT 61,6 million increase in repricing of capital funds and the MNT 294,6 million increase of profits.

	2002	2001
Өөрийн хөрөнгийн өгөөж Return on equity (ROE)	68,2 %	57,4 %
Активын өгөөж Return on assets (ROA)	14,4 %	13,1 %
Нийт зардал/орлогын харьцаа Expense/income ratio	71,7 %	83,8 %

Тайлант онд өнгөрсөн онтой харьцуулахад банкны өөрийн хөрөнгийн өгөөж 10,8 нэгж хувиар, активын өгөөж 1,3 нэгж хувиар тус тус нэмэгдэж, нийт орлогод нийт зардлын эзлэх хувийн жин 12,1 нэгж хувиар буурсан.

In the reporting year, return on equity increased by 10,8 basic points and the return on assets increased by 1,3 basic points. The expense/income ratio decreased by 12,1 basic points.





## Банкны шалгуур үзүүлэлт

Тайлант онд Монголбанкнаас тогтоосон арилжааны банкны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүдийг үндсэнд нь сар дараалан хангаж ажилласан. Эдгэр шалгуур үзүүлэлтүүдийг оны эцэст хэрхэн хангаж ажилласныг дараахь хүснэгтээр харуулав.

## Performance ratio

